

## 2011 ОНООС ХЭРЭГЖИХ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨСЛҮҮДИЙН ЧИГЛЭЛ

№	Төслийн нэр	Үр дүнгийн шаардлага
<b>БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ</b>		
1	Ноос, ноолуур угаах жижиг, дунд үйлдвэрүүдийн технологийн хаягдал усанд агуулагдах химийн хорт бодис болон анхан шатны угаалганд хэрэглэгддэг усны хэмжээг багасгах туршилт, судалгаа, технологи /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Импортын угаалгын бодис, химийн туслах бодис ба будганд экологийн хяналт тавих нэгдсэн систем</li> <li>- Ноос, ноолуур боловсруулах байгаль орчинд ээлтэй технологийн шийдэл</li> <li>- Үйлдвэрийн хаягдал усанд тавих хяналтын шалгуур үзүүлэлт, стандарт</li> <li>- Үйлдвэрүүдийн хаягдал усанд агуулагдах синтетик угаагч бодис, будгийн концентраци бууралт</li> <li>- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн ус цэвэрлэх бага оврын техникийн шийдэл</li> <li>- Ноос, ноолуур угаадаг бодисуудын мэдээллийн сан</li> <li>- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдэд хэрэглэх гадаргуу идэвхт бодисыг сонгох гарын авлага</li> <li>- Ноос, ноолуур угаах технологийн усыг багасгах арга зам, технологи</li> <li>- Эх орны идэвхжүүлсэн эрдсээр хаягдал усыг стандартын шаардлага хангахуйц хэмжээнд цэвэрлэх, бохир усыг эргүүлэн ашиглах технологи</li> </ul>
2	Геотерм буюу газрын гүний дулааныг ашиглах боломжийг судлах ажлыг өргөжүүлэх /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол орны геотермийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх</li> <li>- Геотермийг дулаанд ашиглах боломжийн судалгаа, технологийн загвар</li> <li>- Газрын гүний дулааныг эрчим хүчний зориулалттай ашиглах, геотермаль цахилгаан станц байгуулах боломжийн судалгаа</li> </ul>
3	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн аялал, жуулчлалын бүсүүдийн нөөц даацын судалгаа /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулдаг явуулах жуулчны бааз, зочид буудал, амралт, рашаан сувиллын газрын тоо, хүчин чадал, эрхлэх үйл ажиллагааны төрөл байршлын судалгаа</li> <li>- Улсын тусгай хамгаалалтанд авах шалгуурын үнэлгээ</li> <li>- Тусгай хамгаалалттай газар нутаг дахь газар ашиглалтын судалгаа, нэгдсэн бүртгэл</li> </ul>
4	Монгол орны шилмүүст ойн генийн санг хамгаалах, модны үрийн байнгын талбай сонгох /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Ой үүсгэгч, зонхилох нарс, хуш, жодооны генийн сан бүрдүүлэх, хамгаалах үндэслэл</li> <li>- Ой-ургамалжилтын муж, хошуу тус бүрд шилмүүст модны үр бэлтгэх байнгын талбай бий болгож, үрийг тогтмол бэлтгэх</li> <li>- Элит ба сайн чанарын шилмүүст модны үрийн нөөцтөй болох, тэдгээр үрийг хадгалах заавар, зөвлөмж боловсруулах</li> <li>- Генийн удам сайтай шилмүүст модыг байгальд сонгох, бүртгэлд хамруулах</li> <li>- Ховор, ховордсон шилмүүст модны генийн санг (дендроучастка) хадгалах зориулалттай мод үржүүлгийн газар бий болгох</li> </ul>
5	Хүний болон байгалийн нөлөөгөөр доройтсон газрыг биологийн болон биогеотехнологийн аргаар нөхөн сэргээх технологи боловсруулах /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Байгалийн сөрөг нөлөөгөөр элэгдэж, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх технологи</li> <li>- Атаршсан газрын хөрсийг нөхөн сэргээх технологи</li> <li>- Хэвийн төлөв байдлаа алдсан газрын хөрсийг биологийн аргаар нөхөн сэргээх стандарт боловсруулах</li> <li>- Хортой химийн бодисыг хоргүйжүүлэх чадвар бүхий биоиндикатор бичил биетнүүдийн омгийг гаргах судалгаа</li> <li>- Хүрээлэн буй орчны химийн бодисын бохирдлыг индикатор организмуудаар эрт илрүүлэх аргачлал</li> <li>- Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд биогеотехнологийн аргаар гаргаж авсан нянгуудыг хэрэглэх технологи (технологийн заавар)</li> </ul>
6	Гадаргын болон газрын доорхи усны нөөц, эх үүсвэрийн үнэлгээ хийх /2011/	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаргын болон газрын доорхи усны нөөцийн шинэчилсэн судалгаа</li> <li>- Шинэ усны нөөцийн хайгуул, эх үүсвэрийн үнэлгээ</li> </ul>

7	Полихлорт бифенилийн хөрс, усны бохирдол, бохирдлыг цэвэрлэх технологийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Полихлорт бифенилээр бохирдсон газрууд болон бохирдуулагч эх үүсвэрүүдийг олж тогтоох</li> <li>- Хүний эрүүл мэнд, байгаль орчинд хамгийн их эрсдэл бүхий газрууд дээр нарийвчилсан судалгаа</li> <li>- Полихлорт бифенилээр бохирдсон хөрс, усыг цэвэрлэх, хоргүйжүүлэх технологийг боловсруулах.</li> </ul>
8	Мазаалай баавгай ( <i>Ursus arctos isabillenus</i> )-н генийн сан бүрдүүлэх /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Мазаалай баавгай (<i>Ursus arctos isabillenus</i>)-н генийн сангийн судалгаа</li> <li>- Генийн санг буй болгож, хамгаалах, өсгөн үржүүлэх генетик үндэслэл боловсруулах</li> </ul>
9	Туул голын газрын доорхи усны тэжээгдлийн судалгаа ба бохирдлын мониторинг үнэлгээ /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Туул голын газрын доорхи ба гадаргын усны динамик хамаарлын загвар</li> <li>- Туул голын газрын доорхи усны тэжээгдлийн судалгаа</li> <li>- Туул голын газрын доорхи ба гадаргын усны ба бохирдлын мониторинг үнэлгээ</li> <li>- Газар доорхи усыг зохиомлоор арвижуулах боломж, усан хангамжийн шинэ эх үүсвэрийг тогтоох судалгаа</li> </ul>
<b>БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ</b>		
10	Цэргийн удирдлага, холбооны үндэсний технологи /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл холбооны системийн аюулгүй ажиллагаа, нууцлалыг хангах үндэсний технологи боловсруулах</li> <li>- Хуягт тээвэрлэгч дээр тоногдсон мэдээлэл холбооны сүлжээний иж бүрэн хөдөлгөөнт төвийн төсөл</li> <li>- Нэгтгэлийн удирдлагын тогтолцооны онолын үндэс, мэдээлэл холбооны системийн зохион байгуулалт бүтэц, техник технологийн шийдэл</li> </ul>
11	Цэргийн нэр томъёоны тайлбар толь /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Цэргийн хэргийн уламжлалт болон орчин үеийн нэр томъёоны тодорхойлолт, ойлголтын судалгаа</li> <li>- “Цэргийн нэр томъёоны тайлбар толь” нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх</li> </ul>
12	Монгол Улсын иргэдийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх тогтолцоо, түүний сургалт бэлтгэлийн агуулга, арга зүйн судалгаа /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын иргэдийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх тогтолцоог улс орны хөгжлийн хандлага, төсөв санхүү, нийгмийн сэтгэл зүйн онцлогтой уялдуулан тогтоох боломжийн судалгаа</li> <li>- Бүх нийтийн цэргийн боловсролын агуулга, арга зүй</li> <li>- Цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах зарим асуудлаар эрх зүйн зохицуулалт хийх зөвлөмж</li> </ul>
<b>БОЛОВСРОЛ, СОЕЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ</b>		
13	Монголын түүхийн их нэвтэрхий толь /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Монголын түүх, соёлын талаарх /800 мянган жилийн өмнөөс одоог хүртэлх/ бүрэн хэмжээний мэдээ, мэдээллийг багатаасан 10 боть, 400 х.х. түүхийн нэвтэрхий толь гаргах;</li> <li>- Тольд Монголын түүхийн нэр томъёо, үйл явдлыг бүхэлд нь хамарсан 10 мянга орчим өгүүлэл, 3000 мянган гаруй гэрэл зураг багатаах;</li> <li>- Тольд Монголын овог аймгуудын үүсэл, тархац, төр, улсын товч түүх, байгууллага, тэдгээрийн үүсэл, үйл ажиллагааны талаарх мэдээллүүд оруулах;</li> </ul>
14	Монгол Алтайн түүх археологийн дурсгалууд /Увс аймаг/ /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Алтайн түүх, археологийн дурсгалуудын иж бүрэн электрон мэдээллийн сан бий болгох;</li> <li>- “Монгол Алтайн түүх, археологийн дурсгалууд – III: Увс аймаг” өнгөт атлас хэвлүүлэх;</li> <li>- Монгол алтайн түүх, археологийн дурсгалуудын нэгдсэн ангилал, он цагын үечлэлийн тухай нэг сэдэвт зохиол бичих;</li> <li>- Орон нутагт түүх археологийн дурсгалыг судлах, баримтжуулах, дэлгэн үзүүлэх дэвшилтэт технологи, тор сүлжээний шинэ арга зүй боловсруулах;</li> </ul>
15	Их, дээд сургуулийн багшийн хөгжил /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Их, дээд сургуулийн багшийн чанарт тавигдаж буй шаардлага, өөрчлөлтийн судалгаа;</li> <li>- Багшийг чадваржуулах сургалтын хөтөлбөрийн санал боловсруулах;</li> </ul>
16	Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчийн сурах хөдөлмөрийн ачаалал /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдын сурах хөдөлмөрийн ачааллын өнөөгийн байдал;</li> <li>- Гадаад улс орнуудын ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдын сурах хөдөлмөрийн ачааллыг тогтоож буй байдал, туршлага, чиг хандлага;</li> <li>- Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчийн хөдөлмөрийн ачааллыг оновчтой тогтоох үндэслэл тооцоо, бодлогын санал боловсруулах.</li> </ul>

17	Ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, байршил, хэв шинж /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хэв шинжийн хөгжил, хэмжээ байршлын судалгааны хүрээнд: <ul style="list-style-type: none"> <li>– Өнөөгийн байдлын судалгаа;</li> <li>– Олон улсын туршлага, төлөв хандлагын харьцуулсан судалгаа;</li> <li>– Хэрэгцээний чиг хандлагыг тодорхойлох;</li> <li>– Оновчтой хувилбар, зураглал боловсруулах;</li> <li>– Үзэл баримтлал боловсруулах;</li> </ul> </li> </ul>
18	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг инновацид шилжүүлэх /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Шинжлэх ухаан, технологийн төслөөр гарсан үр дүнг үнэлэх, дүгнэх арга зүйн баримт бичиг боловсруулах;</li> <li>- Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл бүхий “Инновацийн мэдээллийн сан” бий болгох;</li> <li>- Инновацийн бүтээгдэхүүн бий болхуйц ажлуудын нэгдсэн судалгаа хийх;</li> <li>- Инновацийн шаардлагыг хангасан ажлын үр дүнг сурталчилж, олон нийтэд таниулах зөвлөмж боловсруулах;</li> </ul>
19	Монголын соёлын үйлдвэрлэл, соёл урлагийн хувьсал, өөрчлөлт /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол улсын нутаг дэвсгэр дээр соёлын үйлдвэрлэл эрхэлж байгаа байгууллага, уран бүтээлчдийн дэлгэрэнгүй бүртгэл, орчны стандарт;</li> <li>- Соёлын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин, урын сангийн бодлогын нарийвчсан судалгаа;</li> <li>- Монгол хүний сэтгэлгээний өөрчлөлтийг соёл урлагийн, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн биелэлттэй холбосон судлагаа;</li> <li>- Соёл урлагийн амьдралын чиг хандлага, төлөв байдлын судалгаа;</li> </ul>
20	Гүүний айргийн эх хөрөнгийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Айргийн хөрөнгийг шинжлэх ухааны өгөгдөхүүнээр баяжуулан сан бий болгох, хадгалах технологи;</li> <li>- Гүүний айргийн эх хөрөнгийн үндсэн бичил биетнүүдийн шинж чанарын судалгаа;</li> <li>- Хөрөнгийн хатаалтын явц дахь бичил биетний тэсвэрт чанарын үнэлгээ;</li> <li>- Гүүний саамны хадгалалт, исгэлтийн горим, уламжлалт өвтэй уялдаа бүхий арга хэрэглэгдэхүүнийг бий болгох, сайжруулах;</li> <li>- Шинэ айргийн савлагаа, хэрэглээний явц дахь пробиотик шинж чанарын судалгаа;</li> </ul>
21	Хүн амын урт наслалтад нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол хүний эрүүл, урт наслалтанд нөлөөлөх нийгэм, эдийн засаг, экологи, биоанагаахын хүчин зүйлс болон генийн сан, газар зүй, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг цогцоор судлан тогтоох</li> <li>- Монгол хүн амын урт наслалтын газарзүйн тархалтын атлас гаргах</li> <li>- Эрүүл, өндөр наслалтанд нөлөөлж буй биологи, клиник болон физиологийн хүчин зүйлүүдийг тодорхойлох, үндэсний хэмжээний мэдээллийн сан бүрдүүлэх;</li> <li>- Монгол хүн амын насжилтыг уртасгаж, эрүүл аж төрөх дадал бий болгох зөвлөмж боловсруулах;</li> </ul>
22	Монголын казахын бүргэдчидийн түүх, соёлын өв уламжлал, шинэчлэлтийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Монголын казакуудын бүргэд барих, гаршуулан тэжээх, анд сургах, ан хийх арга технологийн судалгаа;</li> <li>- Бүргэдчидийн хувцас, морины болон бүргэдийг тогог хэрэгсэлийн нарийвчилсан судалгаа;</li> <li>- Экоаялалын шинэ салбарыг үүсгэн хөгжүүлэх боломжийн судалгаа /бүргэдчидийн баяр зохион байгуулах, экоаялалын хөтөлбөр гаргах, сурталчилгааны эх материалууд бүрдүүлэх г.м./;</li> </ul>
<b>ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ</b>		
23	Барилгын шинэ, шинэчилсэн материал үйлдвэрлэх технологи /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын шинэ, шинэчилсэн материал үйлдвэрлэх жор, найрлагыг тогтоож, технологи боловсруулах;</li> <li>- Барилгын материалын шинж, чанарыг сайжруулах хольц, нэмэлт бүтээгдэхүүн гарган авах;</li> <li>- Барилгын шинэ, шинэчилсэн материалын стандарт боловсруулах, эдийн засгийн үр ашгийн тооцоог гаргах;</li> <li>- Барилгын шинэ, шинэчилсэн материал үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрийн техник, эдийн засгийн</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>үндэслэл боловсруулах;</li> <li>- Барилгын шинэ, шинэчилсэн материалын үйлдвэрлэлийн туршилт хийх;</li> </ul>
24	Барилга байгууламжийн газар доорхи бүтээцийн бетоны өгөршилийг багасгах, хүйтэн тэсвэрлэлтийг дээшлүүлэх судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга байгууламжийн газар доорхи бүтээцэд нөлөөлөх хүйтэний болон чийгний хавсарсан үйлчлэлийн судалгаа;</li> <li>- Бетоны өгөршлийг багасгах, бат бөх чанарыг дээшлүүлэх, ашиглалтын хугацааг ихсгэх судалгаа;</li> <li>- Хүйтний болон чийгийн өгөршлийн эсрэг шинж чанар сайтай бетон ба төмөр бетон бүтээцийг цутгах технологи боловсруулах;</li> <li>- Хүйтэний нөхцөлд бетон, төмөр бетон хийц цутгах арга, технологи боловсруулах;</li> </ul>
25	Эрчим хүчний хэмнэлттэй барилгын удирдлагын систем /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон био-экологийн шаардлагыг бүрэн хангасан барилгын стандарт загвар боловсруулах;</li> <li>- Дулаан алдагдалыг багасгах, эрчим хүчийг зөв зохистой ашиглах автомат удирдлагын систем боловсруулах;</li> <li>- Удирдагын системийн загварыг туршин дулаан алдагдал, эрчим хүчний хэмнэлтийн тооцоог гаргах;</li> </ul>
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР</b>		
26	Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын стратегийн эрсдэлийг үнэлэх, прогноз хийх арга зүй боловсруулах</li> <li>- Онцгой байдлын улмаас үүдэлтэй стратегийн эрсдэлийг үнэлэх</li> <li>- Монгол Улсын нийгэм, эдийн засаг, байгаль орчинд болзошгүй гамшгийн үүсгэх эрсдэлийг бууруулах зөвлөмж боловсруулах</li> </ul>
<b>ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР</b>		
27	Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан үндэсний криптологийн арга боловсруулах судалгаа /Ассиметр криптографын арга ба криптоанализ/ /2011-2012/	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний криптологийн арга боловсруулах судалгаа хийх /бусад орнуудтай харьцуулсан байдлаар/;</li> <li>- Нууцын зэрэг бүхий мэдээ, мэдээллийг сүлжээгээр нууцлан дамжуулах хос түлхүүрийн арга боловсруулах;</li> <li>- Тоон гарын үсэг, үндэсний тоон түлхүүрийн дэд бүтэц, сүлжээний аюулгүй байдлыг хангах програм болон техник хангамж бий болгох;</li> <li>- Алгоритмийн нууцын зэрэглэл, тайлагдах магадлал, тайлах хугацааны талаарх математик баталгаа боловсруулах;</li> <li>- Улсын хэмжээнд мөрдөгдөх криптологийн стандартуудыг боловсруулах;</li> </ul>
<b>ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ</b>		
28	Монгол хүний удамшлын мэдээллийн өгөгдлөлийн үндэсний сан бүрдүүлэх, түүнийг гэмт хэрэг илрүүлэхэд хэрэглэх судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- “Монгол улсад сайн дурын болон эрсдэл бүхий хүмүүсийн генийн бүртгэлийн хууль” боловсруулах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах</li> <li>- Монгол хүний ДНХ-ийн зарим полиморф маркераар “Удамшлын мэдээллийн өгөгдлийн үндэсний сан” бүрдүүлж, практик хэрэглээ болгох</li> <li>- “Удамшлын мэдээллийн өгөгдлөлийн үндэсний сан”–г гэмт хэргийг илрүүлэхэд ашиглах Монгол улсын стандарт гаргах</li> </ul>
29	Гэмт хэрэгтэй тэмцэхэд полиграфыг ашиглах арга зүйн иж бүрэн судалгааг хийх “Полиграф” төсөл /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Гэмт хэрэгтэй тэмцэхэд полиграфыг ашиглах арга зүйн иж бүрэн судалгаа</li> <li>- Гэмт хэргийн илрүүлэлтийн түвшингийн судалгаа</li> </ul>
<b>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ</b>		
30	Бүс нутгийн хөрс, уур амьсгалд дасан зохицох чадавхитай үр тарианы ургамлын шинэ сорт	<ul style="list-style-type: none"> <li>- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, өвчинд тэсвэртэй буудайн болон бусад үр тарианы /арвай, хошуу будааны г.м/ сортын параметр боловсруулах, сорт гарган нутагшуулах,</li> <li>- Бүс нутагт зохицсон сортын бүтцийг тогтоох</li> </ul>

	/2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Гантай нөхцөлд жишиг сортоос 10-15% нэмүү ургацтай дасан зохицх чадавхитай буудайн 1 сорт бүтээн нутагшуулах</li> <li>- Маркер ген ашиглан навчны зэв өвчинд тэсвэртэй 1 сорт гарган УСС-д шилжүүлэх</li> <li>- Сортын ган халуун тэсвэрийг үнэлэх арга технологи боловсруулах</li> <li>- Усалгаатай нөхцөлд зохицсон буудайн эрчимжсэн сорт гаргах, үрийн эх материалтай болох</li> </ul>
31	Жимс, жимсгэнийг нутагшуулах, байгаль цаг уурын нөхцөлд зохицсон сорт, дээжүүдийг бий болгох, ургуулах агро технологи судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Хурдавчилсан аргаар жимс, жимсгэнэ ургуулах технологи боловсруулах</li> <li>- Эх сорттой харьцуулахад тосны агууламж нэмэгдсэн, өргөс багатай, бяцралтыг бууруулсан, сахарын агуулалт өндөртэй чацарганы селекцийн эх материал нэгийг гаргах</li> <li>- Байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицсон алим, чавга, бөөрөлзгөний сорт шалгаруулах, селекцийн эх материал гаргах</li> <li>- Хамгаалагдсан хөрсөнд гүзээлзгэнэ тариалах агротехнологи боловсруулах</li> <li>- Үхрийн нүдний сахарын агууламж өндөртэй, эх сортоос нэмүү ургацтай селекцийн эх материал нэгийг гаргах</li> </ul>
32	Ургамлын өвчин, хортонтой тэмцэх биобэлдмэл гаргах, хог ургамалтай тэмцэх технологи боловсруулах /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Тариалангийн талбайд тархсан зарим хогын ургамалтай тэмцэх микробиологийн бэлдмэл гарган авах технологи</li> <li>- Үр тарианы хортонтой тэмцэх бэлдмэл гарган авах технологи</li> <li>- Хүнсний ногооны хортон, шавьжтай тэмцэх бэлдмэл гарган авах технологи</li> <li>- Хүнсний ногооны зарим төрлийн өвчинтэй тэмцэх бэлдмэл гарган авах технологи</li> <li>- Ургамалд өвчин үүсгэгч бактери мөөгөнцөрийн эсрэг хам үйлчилгээтэй биофунгицидын технологи</li> <li>- Таримал ургамлын хортон шавжийн эсрэг үйлчилгээтэй бичил биетний нутгийн омгийн судалгаа, биобэлдмэлийн технологи</li> <li>- Бэлчээрийн хөнөөлт царцаа, ойн хортон шавжид өвчин үүсгэгч мөөгөнцрийн нутгийн омгийн судалгаа, биобэлдмэлийн технологи</li> </ul>
33	Экологийн цэвэр бордоо /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Экологийн цэвэр бордоо гарган авах дэвшилт технологи боловсруулах, агрохимийн үнэлгээ хийх, стандарт боловсруулах</li> <li>- Экологийн цэвэр бордоог хэрэглэх аргачлал боловсруулах</li> <li>- Экологийн цэвэр бордооны бага оврын үйлдвэрийн ТЭЗҮ, технологийн зааварыг боловсруулах</li> <li>- Хөрсний үржил шимийг сайжруулах, бордох аргачлал</li> </ul>
34	Махны болон нэн нарийн ноост хонины шинэ хэвшлийн сүрэг бий болгох /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Махны болон нэн нарийн ноост шинэ хэвшлийн хонь бий болгох</li> <li>- Махны болон нэн нарийн ноост шинэ хэвшлийн хонь үржүүлэх арга, тэжээллэг, маллагааны технологи</li> <li>- Махны болон нэн нарийн ноост шинэ хэвшлийн үржлийн болон шилмэл хээлтүүлэгч хонины тоо толгойг нэмэгдүүлэх</li> <li>- Өсвөр хонины махны гарц, чанарын судалгааны дүн</li> <li>- Нэн нарийн ноост шинэ хэвшлийн хонины ноосны гарц, чанарын судалгааны дүн</li> </ul>
35	Удам зүйн үнэлгээнд үндэслэн малын ашиг шимийг нэмэгдүүлэх, тэсвэрт чанарыг сайжруулах арга зам /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Цөм сүргийн малын ДНХ-ийн дэс дарааллыг тогтоож, генетик нөөцийг хянан баталгаажуулах судалгаа</li> <li>- Иммуногенетикийн шинжилгээгээр болон үр төл, ашиг шимт чанараар шалгарсан удам, удам үндэслэгчийг сонгох</li> <li>- Микросателлитуудын үзүүлэлтээр үүлдэр, омог, хэвшлүүдийн хоорондох генеалог холбоог илрүүлэх</li> <li>- Сонгосон удам үндэслэгчийг ашиглан монгол малын тэсвэрт чанарыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх генетик, селекцийн оновчтой загварчлалыг боловсруулах,</li> <li>- Генетик, селекцийн судалгааны дүнг үндэслэн малын ашиг шимийн дээшлэлт, ашигтай шинж чанарын эдийн засгийн үнэлэмжийг тооцох</li> </ul>
36	Биогеоценозын хамаарал бүхий өвчний оношлогоо, эм бэлдмэлийн технологи	<ul style="list-style-type: none"> <li>- Баруун бүсийн аймгуудад экологийн өөрчлөлтөөс шалтгаалан гарч буй хордлогот болон орогномол өвчний гаралт, тархалтын судалгааг улирлын хамаарал, хөрс, усны бохирдол,</li> </ul>

	/2011-2013/	<p>ургамлын ургалтын үе шаттай холбон судалж, зураглал зохион, математик загварчлал боловсруулах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орогномол болон хордлогот өвчнүүдийн шалтгааныг тогтоох эсийн түвшний судалгаа</li> <li>- Хорт ургамлын хордлого болон эрдсийн солилцооны эмгэгийг оношлох түргэн тест болон молекул биологийн арга боловсруулах</li> <li>- Цикутоксины хордлогоос урьдчилан сэргийлэх өвөрмөц бэлдмэл гарган авах</li> <li>- Бүс нутгийн онцлогт тохирсон орогномол болон хордлогот өвчнөөс сэргийлэх, эмчлэх хосолмол үйлчилгээтэй бэлдмэлүүдийн технологи боловсруулах</li> <li>- Нанотехнологийг ашиглан эфирийн тос болон бентонит агуулсан (энтеро сорбент) бэлдмэлүүдийн шинэ технологи</li> <li>- Мал, амьтны тэжээл боловсруулах замын эмгэгийн үед хэрэглэх “Флатан” бэлдмэлийн технологи</li> <li>- Малын ашиг шимийг нэмэгдүүлж, үргүйдэл сувайралтаас сэргийлэх эстроген болон шар буурцаг, үл орлогдох амин хүчил агуулсан сувиллын бэлдмэлүүдийн технологи боловсруулах</li> <li>- Байгаль цаг уурын хүнд нөхцөлд бүх төрлийн малын хээлийг хамгаалах ионт органик бэлдмэлийн шинэ технологи</li> <li>- Инсулинд тэсвэрлэх чанарын нөлөөгөөр үүсдэг адууны догол өвчнийг шинээр оношлох ба тандах судалгаа</li> <li>- Рекомбинат ДНХ-ийн технологиор инсулин дааврын бэлдмэл гарган авах дэвшилтэт технологи</li> </ul>
37	Шинээр болон дахин сэргэж буй мал, амьтны халдварт өвчний тандалт, тархвар судлал, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Лептоспироз өвчний тархвар судлал /ийлдэс, нян болон молекул биологийн арга/, эрсдлийн үнэлгээ, оношийн цомог,</li> <li>- Хулгана тахал /туляреми/-ын тархвар судлал /ийлдэс, нян болон молекул биологийн арга/, эрсдлийн үнэлгээ, оношийн цомог,</li> <li>- Малын боом өвчний үүсгэгчийн байгалийн голомтыг \хөрс\ бүс нутгаар тодорхойлж зураглал</li> <li>- Шинээр гарч болзошгүй зарим зооноз вируст /баруун Нилийн халдвар, хачигт энцефалит/ өвчний ийлдэс судлал, молекул биологийн тандалтын судалгаа, эрсдлийн үнэлгээ</li> <li>- Крым-Конгын цусархаг халуурал өвчний тандан судалгаа хийх</li> <li>- Адууны тархи, нугасны үрэвсэл /Япон, Дорнод ба Баруун Америк, Венесуэл/-өвчний тандалт, ялгаврлан оношлох арга, эрсдлийн үнэлгээ</li> <li>- Малын висна- маеди өвчнийг оношлох бэлдмэлийн загвар боловсруулан турших</li> <li>- Адууны вируст артерит, хөх хэлтэх өвчний оношлуурын технологи боловсруулах</li> <li>- Галзуу өвчнийг оношлох \гэрлийн микроскопын арга/, эмчлэх, сэргийлэх бэлдмэлийн загвар \өгөөш вакцин\ боловсруулан турших</li> <li>- Неоспороз, бог малын бабезиоз өвчний молекул биологийн тархалт, эрсдлийн үнэлгээ</li> <li>- Халдварт өвчин дамжуулагч цус сорогч шавжийн молекул биологийн судалгаа, өвчин үүсгэгч дамжуулах эрсдлийн судалгаа</li> <li>- Үхрийн цистециркозын эпидемиологийн судалгаа, тэмцэх сэргийлэх аргачлал боловсруулах</li> <li>- Сормуустнаар үүсдэг гиардиоз (лямблиоз)-ын тандан судалгаа, эрсдлийн үнэлгээ</li> <li>- Мал, амьтны халдварт өвчний бүртгэл, мэдээллийн үндэсний систем, эрсдлийн үнэлгээ, эдийн засгийн хохиролыг тооцох аргачлал, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний аргачлал</li> <li>- Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнийг ПГУ-аар оношлох өвөрмөц праймер нийлэгжүүлэх, үнэлгээ хийх</li> <li>- Хүнсний хордлого, халдвар \S. enteritidis, S. Typhimurium, E. Coli, Staph.aureus\ -ыг оношлох иммунохроматографийн (ICT) оношлуур</li> <li>- Афлатоксин илрүүлэх түргэн оношлуур</li> <li>- Мал, амьтны махны төрлийг ялгаварлан таних ДНХ оношлогооны арга</li> </ul>
38	Хам, олон цэнэт болон рекомбинант вакцины үйлдвэрлэлийн технологи,	<ul style="list-style-type: none"> <li>- Гахайн салмонеллээ, колибактериоз, ёлом, цусан халдвараас сэргийлэх хам вакцины загвар</li> <li>- Лептоспирозоос сэргийлэх 3 цэнэт вакцины загвар</li> </ul>

	вакцины омгийн молекул биологийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Хонь, ямааны цэцэг өвчнөөс сэргийлэх эсийн өсгөвөрт хам вакцины загвар</li> <li>- Боомоос сэргийлэх рекомбинант вакцины загвар</li> <li>- Шөвөг яр өвчнөөс сэргийлэх эсийн өсгөвөрт вакцины шинэ технологи</li> <li>- Адууны бабезиозоос сэргийлэх рекомбинант вакцины загвар</li> <li>- Боом, дотрын халдварт хордлого, микоплазм өвчний вакцины омгийн молекул генетикийн үзүүлэлтийг тодорхойлж, үнэлэлт өгөх</li> <li>- Вакцины шинэ үеийн хүчлүүр, иммуностимуляторын технологи</li> </ul>
39	Ноос, ноолууран, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварын судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Ноосон бэлэн бүтээгдэхүүний зунгагны үнэр дарах, сэвийг багасгах технологийн шийдэл</li> <li>- Ноолууран бүтээгдэхүүний бүрзийлт, богиноссон ширхэгтүүдийн бөөгнөрлийг арилгах технологийн шийдэл</li> <li>- Монгол хонины ноосон ширхэгтэд тохирсон будагч бодисыг тогтоох судалгаа</li> <li>- Зарим шилмэл омгийн хонины ноосыг тусгайлан бэлтгэж бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулах, орон нутагт үйлдвэр байгуулах судалгаа, туршилтын ажил</li> <li>- Ноосны хялгас ашиглан эрэлт өндөртэй шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн шийдэл</li> <li>- Ноосон ширхэгт материалын хаягдал ашиглан гутлын зориулалттай шинэ материал гарган авах технологи, туршилт</li> <li>- Хонины ноосыг биотехнологийн аргаар боловсруулж хайрсыг нимгэрүүлэх болон нанотехнологийн боловсруулалт хийх технологийг нэвтрүүлэн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх шийдэл</li> </ul>
40	Арьс, ширэн түүхий эдийн чанар хамгаалах дэвшилтэт технологийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Арьс шир боловсруулах байгаль орчинд сөрөг нөлөө багатай технологийн иж бүрэн судалгаа, нэвтрүүлэлт</li> <li>- Малын гаралтай түүхий эдийн гэмтлийн бүсчилсэн судалгаа, ангилал, гэмтлийн нано хэмжээст түвшний шинжилгээ, судалгаа</li> <li>- Орон нутагт /сум бүрт/ хэрэгжүүлэх боломжтой, малын гаралтай түүхий эдийн чанар хамгаалах шинэ технологи бий болгох</li> <li>- Малчид, арьс ширэн түүхий эд бэлтгэгчдэд бэлтгэх, чанар хамгаалалт хийх, хадгалах, тээвэрлэх зэрэг үйл ажиллагаанд баримтлах аргачлал, зөвлөмж, гарын авлага</li> <li>- Арьс ширийг химийн хортой бус, хүрээлэн буй орчинд халгүй цэвэр технологиор боловсруулах үйлдвэрлэлийн бүх дамжлагын судалгаа, бүтээгдэхүүний техникийн шаардлагын стандарт</li> <li>- Орон нутагт арьс ширэн түүхий эдийн чанарыг дээшлүүлэх түргэвчилсэн технологи нэвтрүүлэх</li> </ul>
41	Малын дайвар бүтээгдэхүүнд суурилсан биологийн идэвхит нэмэлт хүнс үйлдвэрлэх технологийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Дайвар бүтээгдэхүүний хүнс тэжээлийн болон физиологи-биологийн үнэт чанарын судалгаа</li> <li>- Дайвар бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтийн судалгаа</li> <li>- Дайвар бүтээгдэхүүний биохимийн найрлага, чанарын онцлогт үндэслэн зохистой боловсруулах технологи</li> <li>- Биологийн идэвхит бодисын /уураг, эрдэс, хүнсний ислэг/ агууламжийг нэмэгдүүлсэн, хадгалалт даах чадвартай 5-6 шинэ нэрийн бүтээгдэхүүний технологи</li> <li>- Дайвар бүтээгдэхүүнд суурилсан биологийн идэвхит бүтээгдэхүүн үйлдвэрлэх загвар цехийн төсөл, технологийн заавар</li> <li>- Дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлд мөрдөх Үйлдвэрлэлийн зохистой дадал, Эрүүл ахуйн зохистой дадлын загвар гарын авлага</li> </ul>
42	Монгол хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх технологийн шийдэл боловсруулах судалгаа	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол хонины ноосны бүтэц, шинж чанарыг бусад орны хонины ноостой харьцуулсан судалгаа</li> <li>- Монгол хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх технологийн параметр, онолын үндэслэл</li> <li>- Хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх технологийн шийдэл, барилгын хийцийн тойм судалгаа</li> <li>- Хонины ноосон барилгын дулаалгын материалыг бусад дулаалгын материалтай харьцуулсан судалгаа</li> <li>- Хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж</li> </ul>

		сонголт, хагас үйлдвэрлэлийн туршилт
<b>ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ</b>		
43	Нарны эрчим хүчийг ашиглах /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Говь хээрийн бүсэд нарны дулааны цахилгаан станцыг байгуулах шинжлэх ухаан, техник, технологийн үндэслэл, зураг төсөл, санал зөвлөмж;</li> <li>- Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийг нарны эрчим хүч ашиглан халаах нар-цахилгаан хосолсон халаалтын системийн туршилтын загвар техник-эдийн засгийн үндэслэл;</li> <li>- Нарны энергийг халаалт, халуун усны зориулалтаар ашиглах, туршилтын загвар, техник-эдийн засгийн үндэслэл;</li> </ul>
44	Монголын цахилгаан эрчим хүчний системийн статик, динамик тогтворжилтын судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Цахилгаан эрчим хүчний системийн статик, динамик тогтворжилтийн судалгаа, тооцоо;</li> <li>- Статик ба динамик тогтворжилтын тооцооны генераторуудын техникийн өгөгдлийн судалгаа</li> <li>- Цахилгаан системийн тогтворжилт алдагсанаас үүдэн эрчим хүчний системд гарах аваарын сөрөг үр дагавар болон хохиролын тооцоо судалгаа;</li> <li>- Цахилгаан эрчим хүчний системийн тогтворжилтын нөөцийг тодорхойлох, тогтворжилтыг дээшлүүлэх арга хэмжээг боловсруулах;</li> </ul>
45	Молибдены баяжмалаас рени ялгаж авах техник технологийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Хийн фаз дахь болон уусмал дахь ренийг бүрэн ялгаж авах технологи боловсруулах</li> <li>- Молебденийн баяжмал боловсруулах үйлдвэрт рени ялгах оновчтой технологи боловсруулан үйлдвэрт нэвтрүүлэх, түүний стандартыг батлуулж, мөрдүүлэх</li> <li>- Экспортын чиглэлийн шинэ бүтээгдэхүүн болох рениг ялган авах эдийн засгийн үр ашгийг тооцоолох, ТЭЗҮ боловсруулах</li> </ul>
<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ</b>		
46	Уламжлалт эмт бодис, эм тан, шинэ эмийн хими-фармакологи, эмнэл зүйн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Зарим өвчнөөс сэргийлэх, эмчлэх үйлдэлтэй уламжлалт эмт бодис, шинэ эмийн хими-фармакологи, эмнэл зүйн судалгаа, стандарт, хэрэглэх заавар</li> <li>- Зарим өвчний эсрэг үйлдэлтэй, ургамал, амьтаны гаралтай нэгдэл, нийлмэл найрлагатай уламжлалт эм тан, шинэ эмийн хими-фармакологийн судалгаа</li> <li>- Монгол оронд зонхилон тохиолддог өвчний эсрэг үйлчилгээг зарим ургамалд илрүүлэх дүн</li> <li>- Ховор болон ховордсон эмийн ургамлыг тарималжуулах агротехникийн үндэслэл, технологи</li> </ul>
47	Монголын уламжлалт анагаах ухааны эм, бэлдмэл зарим нийлмэл жорын бактер, вирүсийн эсрэг үйлчлэлийг тогтоох судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Чихэр өвсний гепатитын С вирүсийн эсрэг үйлчилгээг судлан тогтоосон дүн</li> <li>- Уухаар буюу тарьж хэрэглэх гепатитын С вирүсийн эсрэг эм үйлдвэрлэх технологи</li> <li>- Томуугийн вирүсийн эсрэг үйлчилгээг зарим ургамалд илэрүүлсэн дүн</li> <li>- Тарваган тахлын эсрэг эмийн бэлдмэлийн жор, технологи</li> </ul>
48	Монгол орны ашигтай бичил биетэн болон эмгэгтөрөгч нянгийн генотипийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол оронд тохиолдож буй хачигт энцефалит өвчний үүсгэгчийн нутгийн омгийн сан бүрдүүлэн, бусад улсад тархсан омгуудтай жишсэн мэдээллийн сан байгуулах</li> <li>- Хачигт энцефалит өвчний үүсгэгчийн нутгийн омгийн генийн судалгаа</li> <li>- <i>Helicobacter pillory</i> нянгийн нутгийн омгийн генотипийн өвөрмөц шинжийг судлах, нутгийн цэвэр омгийг ялган авах, судалгааны сан бүрдүүлэх</li> <li>- <i>Helicobacter pillory</i> нянг устгахад хэрэглэж буй антибиотикын эсрэг үүссэн олон эмэнд дасалтай нутгийн омгийг тодорхойлон илрүүлэн, олон эмэнд дасалтай <i>H.pillory</i>-гийн генотипийг тодорхойх</li> <li>- Зарим бичил биетний ашигтай шинж чанарын нууцалбарласан гены дарааллыг тогтоох, түүнийг генийн инженерчлэлийн аргаар дээшлүүлэх боломжын судалгаа</li> <li>- Пробиотик, пребиотик бэлдмэл үйлдвэрлэх технологи</li> <li>- Дахин халдвар авсан, эмэнд дасалтай болсон нянгийн үеийн эмчилгээний зөвлөмж</li> </ul>
49	Төрөлхийн гажигийг эрт илрүүлэх, нярайн эндэгдэлийг бууруулахад пренаталь оношлогоог нэвтрүүлэх нь/2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Төрөлхийн гажигийг эрт илрүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа</li> <li>- Нярайн эндэгдлийн шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа</li> <li>- Нярайн эндэгдлийг бууруулахад пренаталь оношлогоог ашиглах, сайжруулах арга, зөвлөмж</li> </ul>
50	Хүний үүдэл эсийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Үүдэл эсийг хүйн цуснаас ба чөмөгнөөс ялгах аргыг харьцуулан туршсан дүн</li> <li>- Үүдэл эсийн физик хими, биологийн шинж чанарыг судлан тогтоосон дүн</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Үүдэл эсийг эмчилгээ оношлогоонд хэрэглэх арга зүй</li> </ul>
51	Рекомбинант вакцины технологи /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Рекомбинант вакцины томуугийн эсрэг үйлчилгээг судлан тогтоосон дүн</li> <li>- Томуугийн вакцин үйлдвэрлэх технологийн заавар</li> <li>- Томуугийн вакцины үйлдвэрийн ТЭЗҮ</li> </ul>
52	Хүнсний бүтээгдэхүүний эрүүл мэндийн эрсдлийн судалгаа /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Хүнсний бүтээгдэхүүний нянгийн бохирдолд нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийн харилцан хамаарлын судалгаа</li> <li>- Хүнсэн дэх нянгийн аюулын шинж чанар, эрүүл мэндийн сөрөг нөлөө, тэдгээрийг бууруулах арга</li> <li>- Зах зээлд худалдан борлуулагдаж буй эх орны үйлдвэрийн мах, махан, сүү, сүүн бүтээгдэхүүний хэвийн микрофлорын үзүүлэлтийг судалгаа</li> <li>- Генийн өөрчлөлттэй импортын хүнсний бүтээгдэхүүний судалгаа, түүний хэрэглээг зохицуулах зөвлөмж</li> </ul>
53	Тархины харвалтын хурц үед түүний хэлбэрүүдийг (ишеми, геморраги г.м) ялган оношилж сэхээх болон эрчимт эмчилгээ хийх дэвшилт арга” “Инсультийн өвчлөл нас баралтын эпидемиологийн мониторинг аргыг туршин нэвтрүүлэх /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Тархины цус харвалтын хурц үед хийх сэхээн болон эрчимт эмчилгээний дэвшилт арга</li> <li>- Тархины цусан хангамж тасалдаж тархинд шигдээс үүсэх харвалтын хурц үед хийх эмгэг жамын эрчимт эмчилгээний аргууд</li> <li>- Тархины цус харвалтын зарим хэлбэрийн үед мэс засал хийх заалтыг боловсронгуй болгох</li> <li>- Амьсгал, зүрх-судасны хурц дутлын хүнд үед хийх сэхээн амьдруулах дэвшилт арга</li> <li>- Инсультийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тасаг (блок) байгуулан ажиллуулах тогтолцоог нэвтрүүлэх (яаралтай, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах г.м)</li> <li>- Инсультийн өвчлөл нас баралтын эпидемиологийн мониторинг аргыг туршин нэвтрүүлэх</li> </ul>
54	Олон байрлалын атеросклерозын оношлогоо, мэс засал, нөхөн сэргээх технологи /2011-2013/	<ul style="list-style-type: none"> <li>- Атеросклерозын хүндрэл болох тархины цус харвалт, зүрхний шигдээс мөчний үхэлээс сэргийлэх арга, технологи</li> <li>- Олон байрлалын атеросклерозыг цогц байдлаар судалж, судалгааны шинэ чиглэл бий болгох</li> <li>- Олон байрлалын атеросклерозын байрлал зүйн онош тогтоосноор судасны цусны урсгалыг нөхөн сэргээх мэс заслын тактикийн асуудлыг боловсруулах</li> </ul>